



**ХЭНТИЙ АЙМГИЙН
ЦЭНХЭРМАНДАЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ**

2026 оны 01 сарын 22 өдөр

Дугаар Н/01

Модот

**Засаг даргын Тамгын газрын өмч
хамгаалах зөвлөл байгуулах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1 дэх заалт, Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2022 оны 04 дүгээр тогтоолын 2 дугаар бүлгийн 2.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Засаг даргын Тамгын газрын өмч хамгаалах зөвлөлийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд:

Дарга Санхүү албаны дарга
Нарийн бичгийн дарга Мал аж ахуйн үйлдвэрлэлийн төлөвлөлт, менежмент,
малын үржил бүртгэлийн асуудал хариуцсан
мэргэжилтэн

Гишүүд Татварын улсын байцаагч
Баянмод багийн Засаг дарга
Архив, бичиг хэргийн эрхлэгч

2.Засаг даргын Тамгын газрын өмч хамгаалах тусгай төлөвлөгөө гаргаж төлөвлөгөөний биелэлтийг хагас, бүтэн жилээр Засаг даргын тамгын газрын даргад танилцуулж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын өмч хамгаалах зөвлөлийн даргад даалгасугай.

3.Эд хөрөнгийн тооллогоор эвдэрч гэмтсэн, ашиглалын хугацаа дууссан, үрэгдүүлсэн албан хаагчдаар нөхөн төлүүлэх арга хэмжээ авч ажиллахыг зөвлөлд үүрэг болгосугай.

4.Энэхүү тушаал гарсантай холбогдуулан Засаг даргын Тамгын газрын даргын 2023 оны 04 дүгээр сарын 28-ний өдрийн А/04 тоот тушаалыг хүчингүйд тооцсугай

ДАРГА



Ү.ИЧИНХОРЛОО